



2023 оны 1-р сарын 25
communications@amcham.mn
+976 99091557
<https://amcham.mn/publications/1>

Хэвлэлийн мэдээ

АмЧам Монголын иэгдүгээр сарын хурлаар Монгол Улс гуравдагч хөршийн бодлогоо туштай хэрэгжүүлэхийг уриалав



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2023 оны 1-р сарын 24-ний өдөр “Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого” сэдэвт хэлэлцүүлгийг Шангри-Ла Улаанбаатарт зохион байгуулав.

2023 оны анхны сар тутмын хуралд АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ричард Буанганд, Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нар хүндэт илтгэгчээр оролцож, зочид төлөөлөгч нарт хандан үг хэллээ.

Элчин сайд Буанганд 2022 онд АНУ-ын Монгол Улстай хамтарсан ажлын талаар дурдахдаа хууль тогтоох үйл явц ил тод бус байгаад санаа зовж, Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин нь “хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй хэвээр төдийгүй импортлогч, экспортлогчдын хувьд хүндрэлтэй хэвээр байгааг” цохон тэмдэглэв. Хэдий нөхцөл байдал ийм байгаа ч 2023 оныг АНУ-Монголын харилцааны жил болгохын төлөө ажиллахыг талуудад уриалж, гуравдагч хөршийн бодлогын хувьд Элчин сайд Буанганд Монголын геополитикийн нөхцөл, түүний сорилтуудыг ойлгож байгаагаа илэрхийлэв.



Элчин сайд Буанганд “Хөршүүдтэйгээ харилцаж, аливаа шийдвэртэй тулгараах үед бид Монгол улсыг өөрийн байр сууринаас сонголт хийх боломжийг баталгаажуулахыг хүсч байна” гэв. Мөн тэрээр “Энэ бол Монгол Улсын ардчилсан институцийг бэхжүүлэх, үндэсний тусгаар тогтнолыг

баталгаажуулах, эдийн засгийг солонгоруулахад чиглэсэн бидний сонирхлын үндсэн зорилго юм” гэж тэмдэглэв.



УИХ-ын гишүүн Дамдины Цогтбаатар “Монгол Улс хоёр хөршийн дунд оршдог онцлог нь дэлхийн олон улстай хил дамнасан харилцааг нээж байна. Интернет, технологид суурилсан харилцаа холбоо нь гуравдагч хөршийн харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой” гэж онцлов. Мөн тэрээр “Цахим шилжилтийн эрин үед Монгол Улс, ард иргэд, тэр дундаа залуучууд өдөр тутам гуравдагч хөршийн мэдээллийн эх сурвалжуудтай харилцаж байна.

Гуравдагч хөршийн бодлого нь олон хүнд хийсвэр мэт санагдаж болох ч уг бодлого нь огтхон ч тийм ойлголт биш, Монгол Улсын нэр төрийг олон улсын түвшинд бэхжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй, ашигтай бодлого юм” гэв.

Түүнчлэн, тэрбээр “Гуравдагч хөршийн бодлого бол хэний ч эсрэг чиглэсэн биш, гагцхүү бүх талуудад ашигтай байх, хамтын ажиллагааг дэмжсэн бодлого мөн.” гэж онцлов.

АмЧам Монголын Тэргүүн ноён Гари Биондо оны анхны уулзалтад хүрэлцэн ирсэн илтгэгч нарт талархал илэрхийлж хэлэхдээ “Монгол Улсын эдийн засаг зөвхөн зэргэлдээ орших хөршүүдээс гадна, хол боловч сэтгэлд ойр байдаг түнш орнуудын хамтын үнэт зүйлс, хамтын ажиллагаагаар тодорхойлогддог” гэж хэлэв. Хурлын төгсгөлд АмЧам Монголын шинэ гишүүдээ (Юнител Групп, ONDO) хүлээн авч, өргөмжлөл гардуулав.



АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол З сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимиын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.